



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2006 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, Засгийн газрын 2006 оны 196 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилтнуудыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмыг боловсруулж батлан мөрдөж ажиллахыг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар /Н.Нацагдорж/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2005 оны 112 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2006 оны
10 сарын 26 өдрийн
527 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар /цаашид газар гэнэ/ нь Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалт, газар, дэд бүтэц, авто зам, байгаль орчны хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, норм дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, эдгээрийн үе шатны төсөл хөтөлбөрүүдийг тодотгож боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, хот байгуулалтын мэдээллийн санг бүрдүүлэх, улс, хотын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, бусад хөрөнгийн эх үүсвэр бүхий улс болон нийслэлийн захиалгатай барилга байгууламж, объектыг шинээр барих, шинэчлэн өргөтгөх, засварлах ажилд батлагдсан хөрөнгийг зориулалтынх нь дагуу зарцуулж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах эрх бүхий улсын үйлдвэрийн газрын статустай мэргэжлийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Авто замын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, барилга, хот байгуулалтын норм, норматив, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч, Ерөнхий менежер, Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.4. Газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр бие даан үйл ажиллагаа явуулж, иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.5. Газрын дарга нь улсын болон хотын төсвийн батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах бөгөөд батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтыг үндэслэн ажиллагсдыг томилох, чөлөөлөх асуудлыг тушаалаар шийдвэрлэнэ. Ажлын шаардлагад зохицуулан тодорхой хугацаагаар гэрээгээр мэргэжлийн хүн авч ажиллуулж болно.

1.6. Улс болон хотын хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн зураг төсвийг захиалж хийлгэхэд салбарын яамдын баталсан зураг төсөв боловсруулах, батлах, зөвшөөрөлцөх зааврыг мөрдлөгө болгоно.

1.7. Газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон банкны харилцах данстай байна.

1.8. Газар нь хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сан болон архивтай байна.

1.9. Газар нь Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Багатойруу-15, Нийслэлийн төр, захиргааны III байр, 4 давхарт байрлана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Газрын даргыг нийслэлийн Засаг даргын захирамжаар томилж чөлөөлнө. Газрын дарга нь Улаанбаатар хотын ерөнхий архитектор байна.

2.2. Газар нь нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтод тулгуурлан жилийн төлөвлөгөөтэй ажиллаж, жилд 2 удаа Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнана.

2.3. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшөлцсөний үндсэн дээр орлогч дарга, ерөнхий инженерийг томилж, чөлөөлнө. Мөн хэлтсийн даргатай байна.

2.4. Газрын дарга нь байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмыг баталж, цалингийн хэмжээг тогтоож мөрдүүлэх бөгөөд ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.5. Газрын даргыг ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, удаан хугацааны сургалт, томилолттой байх хугацаанд газрын удирдлагыг орлогч дарга гүйцэтгэнэ.

2.6. Газрын даргын дэргэд байгууллагын ойрын болон хэтийн зорилт, үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэг бүхий Захиргааны зөвлөлийг ажиллуулж болно. Захиргааны зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын Дотоод журмаар зохицуулна.

2.7. Газар нь барилга, хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн хангамжийн талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий Техникийн зөвлөлтэй байна.

2.8. Газрын даргын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулан ажиллана.

2.9. Газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актууд, нийслэлийн удирдлагаас өгсөн удирдамж болон энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулах ба газрын ажилтнуудын ажлыг удирдан, цаг үеийн ажлыг зохион байгуулна.

2.10. Ажил олгогч нь ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр үнэлэн зохих журмын дагуу шагнаж урамшуулах, сахилгын арга хэмжээ авах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, сургалтад хамруулах зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

2.11. Газар нь орлогоороо зарлагаа нөхөж ажиллах бөгөөд хөрөнгө санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөө гаргаж, захиалгаар ажиллаж буй барилга угсралт, их засварын ажлын техник хяналтын зардлаас үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх зарчмаар ажиллана.

2.12. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст хүргүүлж хянуулна.

2.13. Газрын эрх хэмжээнд багтах асуудлаар байгууллагын шуурхай зөвлөлгөөнийг 14 хоног тутамд хийж, нутгийн захиргааны байгууллагуудын удирдах хариуцлагатны шуурхай зөвлөлгөөний дүн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх болон ажилтнуудаас хариуцан гүйцэтгэх цаг үеийн ажил, албан хаагчдын ёс зүй, хариуцлага, санаачлага, өгсөн үүрэг даалгаварын биелэлт, ажлын арга барил, үр дүнг сайжруулах асуудлыг хэлэлцэн тэмдэглэл хөтлөнө.

2.12. Газар нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх, ажлын байрны тав тух, соёлыг дээшлүүлэх, ар гэр, ахуй амьдралд нь туслалцаа үзүүлэх, хамт олныг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг санаачлан зохион байгуулж ажиллана.

2.13. Газрын дарга байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

2.14. Газар нь хөрөнгө оруулалтыг дэмжих, боловсон хүчнийг сургаж мэргэшүүлэх, бусад орны туршлагыг судлах, хамтран ажиллах гадаад харилцааны чиг бодлогыг тогтоож хэрэгжүүлнэ.

2.15. Газрын дарга нь ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар үүрэг хүлээж ажиллана.

Гурав. Газрын гүйцэтгэх үүрэг

3.1. Газар нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, тухайн жилийн эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргана.

3.2. Газар нь нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн хүрээнд хийгдсэн инженер геологийн судалгаа, бусад зориулалтын зураглал, хилийн цэсийн баталгаат баримт бичгүүд, геодезийн цэг тэмдэгтүүд, зам тээвэр, инженерийн шугам сүлжээний хэтийн төлөвийн зураг төсөл болон бусад холбогдох баримт бичгийг зохих шаардлагын хэмжээнд бүрдүүлж, нууцын болон архивын материалуудын иж бүрэн судалгаа, бүртгэл хөтөлж ашиглах, тодотгол шинэчлэл хийх ажлыг зохион байгуулна.

3.3. Газар нь нийслэл хот болон алслагдсан суурингуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

3.4. Газар нь хот байгуулалтын баримт бичгийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оруулж батлуулах, батлагдсан баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөж шийдвэрлүүлнэ.

3.5. Газар нь холбогдох байгууллагуудтай хамтран нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл хөтөлбөр, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон нийслэлийн захиалгаар шинээр барих, өргөтгөх, засварлах, барилга, инженерийн байгууламжийн зураг төсөл боловсруулах ба техникийн болон зургийн даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгаврыг хянан баталгаажуулна.

3.6. Газар нь батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран барилга байгууламжийн байршил тогтоох болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх баталгаажуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, холбогдох асуудлуудыг боловсруулан Техникийн зөвлөл, Мэргэжлийн комиссын хурлаар хэлэлцүүлэн дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлнэ.

3.7. Газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах барилга, байгууламжийг байршлын онцлог, үндэсний архитектурын уламжлал, орон зайн зохицол, зохиомжинд нийцүүлэн тухайлсан эзэлхүүн төлөвлөлтөөр хэрэгжүүлэх, тохижилт, зам талбай чимэглэл, урлагийн бүтээлүүд, архитектурын жижиг хэлбэрүүдийг цогцолбороор гүйцэтгэх ажлыг зохион байгуулна.

3.8. Газар нь нийслэл хотын хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.9. Газар нь нийслэлийн захиалгаар шинээр барих, өргөтгөх их засвар хийх бүх барилга байгууламж, далан суваг, зам, гэрэлтүүлэгийн болон бусад ажилд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцон жил, хэтийн төлөвлөгөө, зорилтод тусгуулан тухайн ажлыг захиалан гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлд хяналт тавина.

3.10. Газар нь улс хотын захиалгаар баригдах, засварлах бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлэг, барилгын ажлын захиалагчаар ажиллахын дээр гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн Монгол талын хариуцах барилга угсралтын бүх ажлыг хэрэгжүүлж гардан зохион байгуулна.

3.11. Газар нь хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх барилга угсралт, өрөтгөл шинэчлэлт, их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, санхүүжүүлэх, хотын захиалгатай барилгын засварын ажлыг гүйцэтгэх найдвартай гүйцэтгэгч байгууллагыг ажлын шаардлагаар сонгон шууд гэрээ байгуулна.

3.12. Газар нь хотын ерөнхий төлөвлөгөө болон шинээр барих, өргөтгөх барилга байгууламжийн инженерийн хангамжийн техникийн шийдэл гаргахад

санал өгч зураг төслийг зөвшөөрөлцөж хэрэгжилтэнд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангана.

3.13. Газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газар хөдлөлтийн бичил мужлал, инженер геологийн дүгнэлтийг шинэчлэн тодотгох болон байгаль орчны чиглэлийн зураг төслийн баримт бичигт санал дүгнэлт гаргуулах ажилд чиг үүргийнхээ дагуу оролцоно.

3.14. Газар нь хот байгуулалтын баримт бичгийн төслүүдийг олон нийтэд сурталчилж, санал авна.

3.15. Газар нь хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэн мэдээ, мэдээллийн тодотгол, шинэчлэлт баяжилтыг хийх, дэд бүтэц, байгаль орчны мэдээллийн динамик сан байгуулж хот байгуулалтын мэдээллээр иргэдэд үйлчилнэ.

3.16. Газар нь хөрөнгө оруулалтын санхүүжилтын мэдээг сар бүр гаргаж Статистик мэдээлэл, судалгааны газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст гаргаж өгнө.

3.17. Газар нь иргэд, байгууллагын санал хүсэлтийг хуулинд заасан хугацаанд хөнгөн шуурхай шийдвэрлэн мэдээг зохих хугацаанд гаргаж ажиллана.

Дөрөв. Газрын эрх.

4.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалт, газар, байгаль орчин, дэд бүтэц, барилгажилтын норм норматив, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, гарсан зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлнэ.

4.2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төсөл, зургийн даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгавар, инженерийн хангамжийн техникийн нөхцлийн биелэлтэнд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулна.

4.3. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дарааллыг зөрчих, ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, техникийн нөхцлийн бүрдэлгүй барилга, байгууламж барих, архитектур төлөвлөлтийн даалгавар болон зургийн, техникийн даалгаварын шаардлагыг зөрчиж барилга угсралтын ажил гүйцэтгэсэн, газар шорооны ажил хийх явцад нийтийн эзэмшлийн байгууламжийг эвдсэн, зөвшөөрөгдөөгүй цэгт шороо асгасан зэрэг зөрчлийг арилгуулах асуудлыг мэргэжлийн холбогдох байгууллагад тавьж таслан зогсоох ажлыг хамтран шийдвэрлүүлнэ.

4.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх үйл явц хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцэж буй эсэхэд хяналт тавина.

4.5. Барилга байгууламж, их засварын ажлыг гүйцэтгэх технологийн дараалал, батлагдсан зураг төслийг зөрчиж чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд барилга угсралт, их засварын ажлыг зогсоож зөрчлийг арилгуулах улмаар буруутай этгээдийн зардлаар дахин хийлгэж улсыг хохиролгүй болгоно.

4.6. Гүйцэтгэгч байгууллага тухайн санхүүжилтыг зориулалтын бус зүйлд зарцуулснаас гарсан хохирлыг арилгуулах, стандартын шаардлага хангаагүй, чанарын баталгаагүй материал ашиглахыг хатуу хориглож шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар хянуулж шалгуулан, дүгнэлт гаргуулна.

4.7. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж, барилгын ажлын норм, норматив, үнэлгээний дагуу хянаж, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн ажилд тохирсон санхүүжилтын эрх нээх, санхүүжилт хийх, дутуу, чанаргүй гүйцэтгэсэн ажлын санхүүжилтыг хасна.

4.8. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах шатанд барилгын гүйцэтгэлийн зургийг хийлгэж хот байгуулалтын мэдээллийн санд оруулж, иргэдэд хот байгуулалтын мэдээллээр үйлчилнэ.

4.9. Газрын хариуцах асуудлаар онол, арга зүйн хурал, семинар зөвлөлгөөн, сургалт зохион байгуулж ажиллана.

4.10. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх, төрийн захиргааны төв болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай үйл ажиллагааны чиглэлүүд дээр хамтран ажиллана.

4.11. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх зураг төслийн байгууллага, архитектурын дэвшилтэт төлөвлөлт, орон зай ашиглалтыг сайжруулах, барилга угсралтын ажилд шинэ техник технологи нэвтрүүлэх талаар төрийн бус мэргэжлийн байгууллагууд, уран бүтээлчид, инженер техникийн ажилчид, барилгачидтай харилцаж ажиллана.

4.12. Үйлчилгээ, олон нийт, орон сууцны зориулалтаар нийслэлийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламжийн хөрөнгө оруулагч буюу санхүүжүүлэгчийн хүсэлтээр захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлнэ.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл

5.1 Газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын татвар төлнө.

5.2 Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.3 Газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.4 Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага гүйцэтгэнэ.

5.5 Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд хөндлөнгийн шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.6 Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого,

зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөврүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.7 Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баримтлана.

Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах

6.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч өөрийн эрх мэдлийн хүрээнд Газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлэнэ.

Долоо. Хариуцлага

7.1 Газрын дарга, ажилтнууд нь байгууллагын дүрэм, хөдөлмөрийн Дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

7.2 Хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Найм. Бусад

8.1. Энэхүү дүрмэнд нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгуулагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oOo-----